

**“ЭРДЭНЭТ-АВТО ЗАМ”ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн
ээлжит хуралын тэмдэглэл**

2024 оны 04- сарын
28-ны өдөр

№ 01

Баян-Өндөр
сум

Хурал: 2024 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн 11 цагт компанийн байранд хуралдав.

Хурлыг төлөөлөн удирдах зөвлөлийн дарга Д.Дүйнхэржав нээв.

Тооллогын комиссын дарга Э.Хүрэлсүх хуралд саналын эрхтэй оролцох хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт 86%-тай оролцож байгааг төлөөлөн удирдах зөвлөлийн даргад танилцуулав.

Хурал зохион байгуулагчаас хурлын тэргүүлэгчдийг сонгов.

Үүнд:

- | | |
|-----------------|------------------------------|
| 1. В.Оросмаа | Гүйцэтгэх захирал |
| 2. Д.Дүйнхэржав | ТУЗ-ийн дарга |
| 3. Ч.Даваажав | ТУЗ-ийн гишүүн |
| 4. Д.Энхтуяа | ТУЗ-ийн нарийн бичгийн дарга |
- Төлөөлөн удаирдах зөвлөлийн дарга Д.Дүйнхэржав хуралд хэлэлцэх асуудлыг танилцуулав.
1. Компанийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангын талаархи ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэж батлах.
 2. Компанийн 2024 онд гүйцэтгэх ажлын төлөвлөгөөг хэлэлцэж батлах.
 3. Ногдол ашиг хувиарлахгүй тухай ТУЗ-ийн шийдвэрийг танилцуулах. Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн 86% зөвшөөрөв.

Хуралд хэлэлцэх асуудалтай холбогдуулан үг хэлэх санал оруулах хугацааг 3 минутаар тогтов.

Санал:

1. В.Оросмаа Компанийн сүүлийн жилд улс орны нийгэм эдийн засгийн хүндрэл хөрөнгө оруулалт, санхүүгийн тогтворгүй байдлаас шалтгаалж

ажил хийх боломж хөрөнгө мөнгөний дутагдалд орж ашиг орлогогүй ажиллаж байна. Улиралын чанартай жилд 2-3 сард нь ажилтай байдаг. Дэд бүтэцийн салбаруудыг засгийн газраас бодлогоор дэмжиж жижиг дунд үйлдвэрлэлийн зээлд хамаруулах ажиллах нөхцөл, нийгмийн асуудлыг шийдэхэд анхаарч үзэх хэрэгтэй байна.

2. Д.Энхтуяа ажилчидын цалин хөлс үнэ тарифт өөрчлөлт оруулах замын үйлдвэрлэлийн онцлог түүхий эд материалын үнэ, зам барилагын ажлыг үндэсний компаниудаар хийлгэх дотоод зах зээлээ хамгаалах асуудлыг 3.Т.Яамнаас бодлогоор дэмжих ёстой.



3. Д.Дүйнхэржав 2024 онд гүйцэтгэх ажлын төлөвлөгөө, санхүүжилт хөрөнгө оруулалтын ажлын норм норматив үнийн санал машин механизм ажиллах хүчний хүч зэрэг дотоод зохион байгуулалт гэрээ зураг төсөвт анхаарч ажиллая.

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

1. Компаний 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангын талаархи ТУЗ-ийн дүгнэлтыг хэлэлцэж 86%-ийн саналаар батлав.
2. Компанийн 2024 онд гүйцэтгэх ажлын төлөвлөгөөг 86%-ийн саналаар батлав.
3. Ногдол ашиг хувиарлахгүй тухай ТУЗ-ын шийдвэрийн танилцуулж 86%-ийн саналаар батлав.

Тооллогын комисс хувьцаа эзэмшигчдын ээлжит хуралд саналын эрхтэй оролцсон хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцсэн асуудалд өгсөн саналыг тоолсон дүнг танилцуулж тооллогын комиссийн дүгнэлт, тогтоолыг 86%-ийн саналаар батлав.

Хурлын тэмдэглэлтэй танилцсан:

ТУЗ-ийн дарга  Д.Дүйнхэржав
Гүйцэтгэх захирал  В.Оросмаа
ТУЗ-ийн гишүүн  Ч.Даваажав
Тэмдэглэл хөтөлсөн ТУЗ-ийн
нарийн бичгийн дарга  Д.Энхтуяа

